



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/80

Булган сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Ө.Мөнх-Эрдэнэ (ГЖ90062306)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 12 дүгээр гудамж 1205 тоотод байршилтай амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 557 м² газрыг 1067 м² болгон илүү талбайн дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн кадастрын зургийн дагуу газрын хэмжээг өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.

2.Ө.Мөнх-Эрдэнэтэй газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Булган сумын Засаг даргын 2011 оны 175 дугаар захирамжийн Ө.Мөнх-Эрдэнэтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010009